

ОЮУТАН ШИЛЖҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ¹

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг гадаад, дотоодын их сургуулиас МУИС-д, мөн МУИС-ийн хөтөлбөр хооронд оюутан шилжин суралцах асуудлыг зохицуулахад мөрдөнө .

Хоёр. Гадаад, дотоодын их сургуулиас шилжин суралцах

2.1. Дараах нөхцлийн аль нэгийг хангасан гадаад, дотоодын их сургуулиас зохих болзол, нөхцлийг биелүүлсэн оюутан МУИС-д шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

- Тухайн улсын хууль тогтоомжийн дагуу дээд боловсролын байгууллагын буюу хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн, хэрэв ийм тогтолцоо байхгүй бол зөвхөн төрийн өмчийн сургууль;
- МУИС-тай хамтын ажиллагааны болон оюутан солилцох тухай, багц цаг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ байгуулсан гадаад, дотоодын их сургууль;
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн дотоодын их сургууль.

2.2. МУИС-д шилжин суралцах оюутан дараах болзол хангасан байна. Үүнд:

- Журмын 2.1-д заасан гадаад, дотоодын их сургуульд нэгээс доошгүй жил 3.0-аас багагүй голч дүнтэй суралцсан, улиралд дунджаар 12-оос багагүй багц цаг цуглуулсан байх;
- Мэргэжлийн чиглэл, элсэлтийн ерөнхий шалгалтын зөрөөгүй байх;
- Шилжин суралцах шалтгаан тодорхой байх (гадаадын их сургуулиас шилжин ирэх тохиолдолд эрүүл мэнд, ар гэрийн гачигдал болон байгалийн гамшиг, улс төр, эдийн засгийн онцгой, хүнд байдлын улмаас шилжин суралцах зэргийг хамааруулна).

2.3. 2.1. ба 2.2-т зааснаас бусад тохиолдолд МУИС-д шилжин суралцахыг зөвшөөрөхгүй.

Гурав. МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах

3.1. Дараах нөхцлийг хангасан МУИС-ийн оюутан өөр хөтөлбөрт шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

- МУИС-д элсэх болзол хангаж элсэн, нэгээс доошгүй жил 3.0-аас багагүй голч дүнтэй суралцсан байх;
- Мэргэжлийн хөтөлбөр хоорондын элсэлтийн ерөнхий шалгалтын зөрөөгүй байх;
- Суралцаж байгаа хөтөлбөртөө хөнгөлөлттэй нөхцлөөр, эсвэл аль нэг байгууллагын гэрээний дагуу элсээгүй байх;
- Сургалтын төлбөрийн өргүй байх.

Дөрөв. Багц цаг шилжүүлэн тооцох

4.1. Оюутны өмнө үзсэн хичээлийн багц цагийг шилжүүлэн тооцох асуудлыг тухайн бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны эрхлэгч, мэргэжлийн тэнхим/профессорын

¹ Захирлын 2001/627 тушаалаар баталж, 2008.01.08-ны өдрийн 12 тоот, 2011.05. 31-ны өдрийн 304 тоот тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан журмыг шинэчлэн найруулав.

багийн эрхлэгч/ахлагч судлан тогтоож, бүрэлдэхүүн сургуулийн захирал баталгаажуулна.

- 4.2. Оюутны өмнө үзсэн ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдийн багц цагаас 30-аас хэтрэхгүй багц цагийг шилжүүлэн тооцно.
- 4.3. Оюутны тухайн хичээлээр цуглуулсан багц цагийн хэмжээ МУИС-ийн багц цагийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд багц цаг шилжүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах мэтээр нөхөн гүйцээх боломжгүй. Илүү тохиолдолд МУИС-т баримталж байгаа тухайн хичээлийн багц цагаар шилжүүлнэ.
- 4.4. Хэрэв уг сургуулийн багц цагийн тодорхойлолт МУИС-ийнхаас өөр буюу сургалтын агуулгыг цагаар тооцдог бол МУИС-д баримталдаг багц цагийн тодорхойлолтыг үндэслэн бүхэл багц цагт шилжүүлж (0,5-ын нарийвчлалтай) бодно. Жишээлбэл, 40-54 цагийн лекц, эсвэл 32 цагийн лекц ба 16 цагийн семинараар үзсэн хичээлийн багц цагийг 3 гэж авна.
- 4.5. Шалгалтын үнэлгээг оноонд үндэслэн тооцно. Хэрэв уг сургуулийн үнэлгээний тогтолцоо онооноос өөр бол оноонд хэрхэн харгалзуулах тухай албан ёсны тайлбар эсвэл цахим хуудасны бичвэр авчрахыг шаардана. Хэрэв ийм боломжгүй бол амжилттай дүнгийн хуваарийг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцож болно. Тухайлбал, тухайн сургуульд оюутны мэдлэгийг онц, сайн, дунд, муу гэж үнэлдэг бол 60-71, 72-83, 84-95 оноог амжилттай дүнд харгалзуулан дунд - 66, сайн - 78, онц - 90 гэж оноох юмуу, эсвэл үнэлгээг тооцсон багц цагийн нарийвчлалтай холбож багц цагийг буруулан тооцсон бол интервалын дээд оноог, дэвшүүлсэн бол доод оноог харгалзуулж болно.

Тав. Шилжилтийн төлбөр

- 5.1. Шилжиж ирсэн оюутан тухайн улирлын сургалтын төлбөрөөс гадна шилжилтийн төлбөр төлнө. Шилжилтийн төлбөрийн хэмжээг суралцах хөтөлбөрийн эрэлт, өрсөлдөөн, оюутны тоо зэргээс хамааруулан захиргааны зөвлөл жил бүр шинэчлэн тогтооно.
- 5.2. Шилжиж ирсэн оюутан дор дурдсан хүндэтгэх шалтгаантай бол албан ёсны баримт нотолгоог үндэслэн сургалт эрхэлсэн дэд захирал шилжилтийн төлбөрийг 100 хувь хүртэл бууруулан тогтоож болно. Үүнд:
 - а. Өөрөө бүтэн өнчин, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй;
 - б. Ар гэр нь нэн ядуу;
 - в. МУИС-д үндсэн орон тоон дээр сүүлийн 5-аас дээш жил ажиллаж байгаа багш, ажилтны ам бүлд багтдаг төрсөн хүүхэд.
- 5.3. Журмын 5.2-р заалтад дараах албан ёсны баримт нотолгоог үндэслэнэ. Үүнд:
 - (а,б) нөхцөлд оюутны ар гэрийн харъяалагддаг сум, хорооны захиргааны тодорхойлолт;
 - (в) нөхцөлд МУИС-ийн ЗХШҮА-ны тодорхойлолт.
- 5.4. Шилжилтийн төлбөрийн орлогын 50%-ыг суралцах бүрэлдэхүүн сургуульд, үлдэх хэсгийг “МУИС-ийг хөгжүүлэх сан”-д бэлэн бусаар тушаана.

Зургаа. Шилжин суралцах хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт

- 6.1. Шилжин суралцах хүсэлт гаргах оюутан дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - Шилжин суралцах шалтгаанаа тодорхой бичсэн өргөдөл;

- Суралцаж байгаа сургуулийн оюутан мөн болохыг баталсан тодорхойлолт (шилжин суралцах өргөдөл хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тухайн их сургуулиас албан ёсоор ирүүлсэн байх ба заасан хугацаанд багтаж ирэхийг өргөдөл гаргагч оюутан хариуцна);
 - Тухайн сургуулийн сургалтын албаны тамга, тэмдэг, албан тушаалтны гарын үсэгтэй албан бичгийн хуудас дээр тухайн оюутны судалсан хичээлийн нэр, багц цаг, шалгалтын дүнг жагсаасан тодорхойлолт (өргөдөл хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тухайн их сургуулиас албан ёсоор ирүүлсэн байх ба заасан хугацаанд багтаж ирэхийг өргөдөл гаргагч оюутан хариуцна);
 - Бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг батлах баримт бичиг, хуулбарын хамт;
 - Тухайн сургуульд элсэхдээ өгсөн элсэлтийн ерөнхий шалгалтын батламж бичиг, хуулбарын хамт;
 - Үйлчилгээний хураамж төлсөн баримт;
 - МУИС-ийн оюутан өөр хөтөлбөрт шилжих хүсэлт гаргах тохиолдолд өргөдөл (дүнгийн тодорхойлолт ба шаардлагатай бусад мэдээллийг тухайн оюутны шилжин суралцахаар хүсэлт гаргаж буй бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба МУИС-ийн мэдээллийн системээс татаж авна).
- 6.2. Дээр заасан бичиг баримт гадаад хэл дээр бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна.
- 6.3. Хэрэв өргөдөл хүлээж авах хугацаанд дээрх бичиг баримт багтаж ирэхгүй бол тухайн оюутны хүсэлтийг дараа улирлын шилжих хөдөлгөөний хүрээнд шийдвэрлэнэ.

Долоо. Шилжих хүсэлт гаргах хугацаа, хүсэлтийг шийдвэрлэх

- 7.1. Шилжин суралцах тухай өргөдлийг 6.1-т заасан бусад бичиг баримтын хамт тухайн улирал эхлэхээс долоо хоногийн өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба хүлээн авч дууссан байна.
- 7.2. Анги дүүргэлт болон багц цагийн ачааллыг харгалзан бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас гаргасан дүгнэлтийг үндэслэн шилжин суралцах тухай өргөдлийг бүрэлдэхүүн сургуулийн захирал дараагийн улирал эхлэхээс өмнө шийдвэрлэж дуусгана.
- 7.3. Шилжин суралцах болзол хангасан оюутны МУИС-д (эсвэл тухайн хөтөлбөрт харьяалагдах) суралцах эрх МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажна.
- 7.4. Захирлын тушаал гарсны дараа МУИС-ийн мэдээллийн системийг ашиглах эрхийг цахим шуудангаар шилжиж ирсэн суралцагчид илгээж, оюутны үнэмлэх олгоно. (МУИС-ийн мэргэжлийн хөтөлбөр хооронд шилжин суралцагчийн хөтөлбөрийн харьяаллыг мэдээллийн системээр шилжүүлнэ)
- 7.5. Мэргэжлийн хөтөлбөрийн онцлогоос хамааран нэмэлт шалгалт авах, ярилцлага хийх, шилжин суралцах түвшинг тогтоох зэргийг бүрэлдэхүүн сургуулийн дотоод журмаар зохицуулахыг зөвшөөрнө.
- 7.6. Оюутан зөвхөн нэг удаа шилжин суралцахыг зөвшөөрнө.

* * * * * * * * *